

# Монгол улсад үзүүлэх хөгжлийн хамтын ажиллагааны чиглэл

2017 оны 12 дугаар сар

## 1. Улс, бүс нутаг дахь хөгжлийн хамтын ажиллагааны зорилго

Хятад, Орос улсын дунд орших ардчилсан тогтолцоот, Япон улстай нэн дотно харилцаатай Монгол улс тогтвортой хөгжих явдал нь бүс нутгийн тогтвортой байдал, хөгжил цэцэглэлтэд хувь нэмэр оруулах төдийгүй, хоёр орны харилцааны хөгжилд ч ихээхэн утга учиртай юм. Уг үзэл бодолд тулгуурлан Япон улс нь Монгол улсад тууштай дэмжлэг үзүүлж ирсэн бөгөөд Монгол улсыг ардчилсан тогтолцоонд шилжсэнээс хойш хамгийн их тусламж, дэмжлэг үзүүлж ирсэн билээ. Мөн Монгол улс нь олон улсын хамтын нийгэмлэг дэх олон чухал асуудал дээр Япон улсын байр суурийг тууштай дэмждэг найрамдалт харилцаатай улс бөгөөд бүс нутаг, олон улсын тавцан дахь манай улсын хамтын ажиллагааг хөгжүүлэхэд чухал түнш орон юм.

Энэхүү нөхцөл дунд 2010 онд Япон, Монгол улс нь “Стратегийн түншлэл”-ийг байгуулахыг зорьж, хоёр улсын харилцааг улам бүр хөгжүүлэхээр санал нэгдсэн. 2016 оны 6 дугаар сард Монгол улсын хувьд анхных болох Япон, Монголын Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр (EPA) хүчин төгөлдөр болсон нь хоёр улсын түншлэлийг бэхжүүлэхэд онцлон тэмдэглүүштэй явдал болсон. Мөн 2017 онд Япон улс, Монгол улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 45 жилийн ой тохиож, 2021 оны эцэс хүртэлх хугацаанд улс төр, аюулгүй байдал, эдийн засаг, соёл болон иргэд хоорондын харилцаа зэрэг олон салбарт хоёр улсын авч хэрэгжүүлэх хамтын ажиллагааг тодорхой тусгасан “Япон, Монголын стратегийн түншлэлийн дунд хугацааны хөтөлбөр”-т гарын үсэг зурсан бөгөөд олон улсын тавцан дахь хамтын ажиллагаанаас өгсүүлээд хоёр улсын харилцан идэвх санаачлагатай хамтын ажиллагааг нэмэгдүүлснээр, харилцан нэн ашигтай “Стратегийн түншлэл”-ийг байгуулахыг зорилгоо болгохыг нотолсон.

Монгол улсын ашигт малтмалын арвин их нөөц баялаг нь эдийн засгийн өсөлтийн нөөц бололцоог агуулж байдаг тул 2008 онд дэлхийн эдийн засагт тулгарсан Леманы хямралыг нэн даруй даван туулж, 2011 оноос 2013 оны хооронд эдийн засаг эрчимтэй өсөж 10 хувийг давсан. Харин түүний дараа баялгийн үндсэрхэг үзлийг агуулсан, Монгол улсыг чиглэсэн гадаадын хөрөнгө оруулалтыг хязгаарлахад хүргэсэн бодлого, хууль баталсны улмаас гадаадын шууд хөрөнгө оруулалт эрс буурснаас гадна Хятадын эдийн засгийн эрч эрс суларч, дэлхий нийтээр байгалийн баялгийн үнэ буурснаас голлох аж үйлдвэрийн салбар болох уул уурхайн салбар уналтад орсон. 2015 онд эдийн засгийн өсөлт 2.3%, 2016 онд 1% хүртэл буурч, Засгийн газрын төсвийн алдагдал, гадаадын өр ихээхэн нэмэгдсэн. Тиймээс Монгол улсын Засгийн газар 2017 оны 2 дугаар сард Олон улсын валютын сантай хамтран “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр (EFF)”-ийг хэрэгжүүлэхээр тохиролцсон. Олон улсын валютын сан, Япон зэрэг донор орнуудын тусламжаар төсвийн нөхцөл байдлыг баттай шинэчлэх, эрүүл макро эдийн засгийн удирдлагыг хангах, өсөн нэмэгдсэн баян ядуугийн ялгааг багасгах, нийгмийн суурь үйлчилгээг сайжруулахыг зорьж байна. Монгол улсын Засгийн газар Олон улсын валютын сантай тохиролцсон уг хөтөлбөрийг баттай хэрэгжүүлж, төсвийн сахилга батыг ханган ажиллаж, эдийн засгийн шинэчлэлийг баттай хэрэгжүүлж, урт хугацаанд тогтвортой эдийн засаг, төсвийн удирдлагыг хангах хэрэгтэй юм.

Монгол улс нүүрс, зэс, уран, ховор метал, газрын ховор элемент зэрэг газар доорх байгалийн баялаг арвинтай, эдийн засгийн хөгжлийн нөөц бололцоо өндөр. Тиймээс Монгол улс уул уурхайн салбараа тууштай хөгжүүлэхийн зэрэгцээ энэ салбараас олох

орлогыг улсын нийт хөгжилд ашиглавал цаашдын эдийн засгийн өсөлт, хөгжил цэцэглэлтийн түлхүүр болно.

**2. Япон улсын Хөгжлийн албан ёсны тусламжийн үндсэн чиглэл (Том зорилт):** Эдийн засгийн тогтвортой өсөлтийг бий болгох, нийгмийн тогтвортой хөгжлүүлэх

Монгол улс уул уурхайн баялгаа олборлож, энэ салбарыг цогцоор хөгжүүлснээр дунд болон урт хугацаанд хурдан хөгжинө хэмээн үзэж байгаа ч, Монгол улсын эдийн засаг ашигт малтмалын экспортоос ихээхэн хамааралтай тул эдийн засгийг төрөлжүүлэн хөгжүүлэх нь чухал асуудал юм. Мөн төсвийг баттай шинэчилж, цаашид эдийн засгийн өсөлтийг тогтворжуулахын тулд макро эдийн засгийн тогтвортой удирдлагыг хангахын зэрэгцээ эдийн засгийн өсөлтийн үр шимийг олон нийт тэгш хүртэх бодлого явуулах шаардлагатай. Түүнчлэн Улаанбаатар хотод хүн ам хэт төвлөрснөөс үүдэн хотжилтын асуудал, бүс нутаг хоорондын ялгаа улам ихсэж байна. Тиймээс эдийн засгийн хөгжлийг баттай хангахын зэрэгцээ тэрхүү ашиг шимийг бүх давхрагын хүмүүст хангалттай хүртээн, тогтвортой, тэнцвэртэй өсөлтөд чиглэсэн Монгол улсын Засгийн газрын арга хэмжээг манай улс дэмжин ажиллана.

**3. Тэргүүлэх салбар (Дунд зорилт)**

**(1) Эрүүл макро эдийн засгийг бий болгоход чиглэн засаглалыг бэхжүүлэх**

Монгол улсын Засгийн газар эдийн засаг, төсвийн хүндрэлийг даван туулж, эдийн засгийн дунд, урт хугацааны өсөлт, тогтвортой байдлыг хангахын тулд Засгийн газрын төсвийн сахилга бат (төсвийн орлого, зарлагын хяналт зэрэг)-ыг бэхжүүлэх зорилго бүхий олон нийтийн санхүүгийн хяналтын чадварыг дээшлүүлэх, хууль, шүүхийн тогтолцоог бүрдүүлж, хөрөнгийн зах зээлийн чадавхыг бэхжүүлж, хөрөнгө оруулалт, бизнесийн орчныг бүрдүүлснээр гадаадын шууд хөрөнгө оруулалтыг дэмжиж, улмаар эрч хүчтэй зах зээлийн эдийн засгийг хөгжүүлснээр засаглалыг бэхжүүлэх замаар эрүүл макро эдийн засгийг бий болгоход дэмжлэг үзүүлнэ.

**(2) Байгаль орчинд ээлтэй, эдийн засгийн тэнцвэртэй өсөлтийг бий болгох**

Аж үйлдвэрийг төрөлжүүлэн хөгжүүлэх асуудал зогсонги байдалтай байгаагийн дээр орлогын түвшин, бүс нутгийн ялгаа улам бүр ихсэж байгаа тул Монголын талын өөрсдийн санаачлагыг угтвар нөхцөл болгож, тогтвортой уул уурхайн хөгжлийг бий болгоход чиглэн боловсон хүчнийг бэлтгэх, хөдөө аж ахуй, мал аж ахуй зэрэг аж үйлдвэрийн салбарыг төрөлжүүлэн хөгжүүлэх болон эдгээр салбарын боловсон хүчнийг бэлтгэх, орон нутгийн хөгжлийн стратегийг бэхжүүлэх, байгаль орчинд ээлтэй мөн гамшигт тэсвэртэй аюулгүй хот болгон хөгжүүлэх, өсөлтийг дэмжих өндөр чанар бүхий дэд бүтцийг бүрдүүлэх замаар уялдаа холбоог бэхжүүлэх зэрэгт дэмжлэг үзүүлнэ.

**(3) Хүртээмжтэй нийгмийг цогцлоон бий болгох**

Нийт ард иргэд эдийн засгийн өсөлтийн үр шимийг хүртэх боломжоор хангахын тулд эрүүл мэндийн үйлчилгээг нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцсэн түвшинд хүргэж, нийгмийн суурь үйлчилгээний чанарыг дээшлүүлж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоо болон хүртээмжтэй нийгмийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

**(4) Анхаарах зүйлс<sup>1</sup>**

2017 оны 3 дугаар сард хоёр улсын Гадаад хэргийн сайд нар гарын үсэг зурсан “Япон, Монголын стратегийн түншлэлийн дунд хугацааны хөтөлбөр (2017-2021 он)”-ийн зорилгод тулгуурлан харилцан ашигтай, бие биенээ нөхсөн харилцааг бэхжүүлэхэд хувь нэмрээ оруулах хамтын ажиллагааг хэрэгжүүлнэ.

Хавсралт: Төсөл хэрэгжүүлэх төлөвлөгөө

<sup>1</sup>Монгол улсад хэрэгжүүлсэн Хөгжлийн албан ёсны тусламжийн үнэлгээг доорх холбоосоор орж үзнэ үү.

<http://www.mofa.go.jp/mofaj/gaiko/oda/shiryo/hyouka/report/mong3.html>